



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Агт сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/151/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70642580 Цахим хаяг: Ankhubayrd@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	2
1. Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

1. Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 126
танай _____ ны № _____ т

БЯАН-АГТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Агт сумын ЗДТГ-н 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Агт сумын ЗДТГ-н 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:\bichighereg\2022\44\toot

006020258

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР



D:/bichighereg/2022A4toot

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	153,363,236.40	153,019,071.88
33	АВЛАГА	4,613,022.00	11,051,903.98
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	13,022.00	3,172,903.98
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	2,504,000.00
335	Бусад авлага	4,600,000.00	5,375,000.00
3351	Байгууллагаас авах авлага	200,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,400,000.00	5,375,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	145,136,714.40	138,924,705.40
351	Түүхий эд материал	83,818,125.37	83,353,125.37
35110	Тусгай зориулалттай материал	83,818,125.37	83,353,125.37
354	Хангамжийн материал	25,733,589.03	26,696,580.03
35410	Бичиг хэргийн материал	1,979,700.00	2,208,500.00
35420	Аж ахуйн материал	20,477,775.03	21,281,966.03
35430	Сэлбэг хэрэгсэл	1,480,000.00	1,480,000.00
35440	Түлш, шатах тослох материал	200,000.00	200,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,596,114.00	1,526,114.00
35600	Мал амьтад	35,585,000.00	28,875,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	3,613,500.00	3,042,462.50
36300	Тэжээлийн нөөц	3,613,500.00	3,042,462.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,405,445,118.69	1,303,907,597.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,405,445,118.69	1,303,907,597.97
392	Биет хөрөнгө	1,374,945,118.69	1,273,557,597.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	772,142,077.11	772,142,077.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	(262,510,457.06)	(317,617,770.02)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	304,104,800.00	304,104,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(282,665,733.70)	(297,704,311.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	221,496,017.64	231,496,017.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	(189,201,437.83)	(208,366,595.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,130,931.77	40,130,931.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,205,902.42)	(29,509,910.21)
39209	Зам, гүүрийн байгууламж	793,623,014.40	793,623,014.40
39210	Хуримтлагдсан элэгдэл	(23,763,280.32)	(35,644,920.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	62,681,800.00	62,681,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(36,010,872.66)	(42,901,697.58)
39217	Ном	1,124,161.76	1,124,161.76
393	Биет бус хөрөнгө	30,500,000.00	30,350,000.00
39301	Програм хангамж	2,700,000.00	2,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,980,000.00)	(2,130,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	29,780,000.00	29,780,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,558,808,355.09	1,456,926,669.85
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,558,807,555.09	1,456,926,669.85
51	Засгийн газрын хувь оролцоо	1,558,807,555.09	1,456,926,669.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	276,085,820.35	276,085,820.35
51101	Өмч: - төрийн	246,305,820.35	246,305,820.35
512	Хуримтлагдсан үр дүн	1,095,096,310.74	993,215,425.50
51210	Өмнөх үеийн үр дүн	1,095,096,310.74	1,095,096,310.74

51220	Тайлант үеийн үр дүн	-	(101,880,885.24)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	187,625,424.00	187,625,424.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,558,807,555.09	1,456,926,669.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	556,103,884.64	535,873,508.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,524,421.64	10,889,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	76,524,421.64	10,889,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	37,272,775.64	10,889,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	1,944,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	33,772,775.64	8,945,000.00
120009	Бусад орлого	39,251,646.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	479,579,463.00	524,984,308.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	123,331,026.00	103,715,938.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	77,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	123,331,026.00	26,215,938.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	356,248,437.00	421,268,370.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	356,248,437.00	421,268,370.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	633,450,800.03	637,754,393.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	633,450,800.03	637,754,393.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	630,189,060.03	605,578,096.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,810,502.00	233,716,098.54
210101	Үндсэн цалин	168,545,200.00	159,717,108.54
210102	Нэмэгдэл	57,228,218.00	60,460,659.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,037,084.00	13,538,331.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,550,878.00	31,622,899.96
210201	Тэтгэврийн даатгал	20,770,478.00	22,391,248.46
210202	Тэтгэмжийн даатгал	2,445,100.00	2,478,321.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,956,100.00	1,911,664.72
210204	Ажилгүйдлийн даатгал	489,000.00	440,151.69
210205	Эрүүл мэндийн даатгал	4,890,200.00	4,401,513.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,680,775.00	40,687,541.00
210301	Гэрэл, цахилгаан	3,840,791.00	4,210,000.00
210302	Түлш, халаалт	33,839,984.00	36,477,541.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,066,359.10	24,066,530.00
210401	Бичиг хэрэг	2,579,450.00	2,518,520.00
210402	Тээвэр, шатахуун	10,603,829.60	12,298,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,805,200.00	2,203,510.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,874,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	498,000.00	501,200.00
210408	Бараа материал акталсны зардал	15,579,879.50	4,670,000.00

Баян-Агт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,717,600.00	3,029,200.00
210604	Урсгал засвар	7,717,600.00	3,029,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,671,000.00	1,884,000.00
210702	Дотоод албан томилолт	2,671,000.00	1,884,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,450,447.40	2,761,645.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,643,877.40	201,645.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	172,000.00	172,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	183,570.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,100,000.00
210807	Газрын төлбөр	42,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	270,641,498.53	267,210,182.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,103,229.00	154,792,801.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	879,860.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	134,338,269.53	111,537,520.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,261,740.00	32,176,296.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,005,000.00	20,446,570.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,005,000.00	550,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	19,396,570.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	256,740.00	11,729,726.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	256,740.00	11,729,726.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(77,346,915.39)	(101,880,885.24)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	29,499,820.10	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	599,820.10	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	28,900,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(29,499,820.10)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(106,846,735.49)	(101,880,885.24)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	486,500,073.00	537,657,008.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,500,000.00	11,604,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,500,000.00	11,604,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,500,000.00	11,604,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	11,604,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	483,000,073.00	526,052,808.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	126,751,636.00	104,784,438.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	77,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	126,751,636.00	26,215,938.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,068,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	356,248,437.00	421,268,370.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	356,248,437.00	421,268,370.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	486,500,073.00	527,657,008.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	486,500,073.00	527,657,008.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	486,243,333.00	492,458,211.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,810,502.00	237,429,999.77
210101	Үндсэн цалин	168,545,200.00	163,431,009.77
210102	Нэмэгдэл	57,228,218.00	60,460,659.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,037,084.00	13,538,331.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,563,900.00	31,068,880.71
210201	Тэтгэврийн даатгал	20,783,500.00	21,770,666.86
210202	Тэтгэмжийн даатгал	2,445,100.00	2,418,333.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,956,100.00	1,934,789.59
210204	Ажилгүйдлийн даатгал	489,000.00	456,158.97
210205	Эрүүл мэндийн даатгал	4,890,200.00	4,488,931.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,680,775.00	40,687,541.00
210301	Гэрэл, цахилгаан	3,840,791.00	4,210,000.00
210302	Түлш, халаалт	33,839,984.00	36,477,541.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,481,900.00	20,164,991.00
210401	Бичиг хэрэг	2,307,700.00	2,640,920.00
210402	Тээвэр, шатахуун	10,316,200.00	12,298,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,858,000.00	2,300,920.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	924,251.00
2105	Нормативт зардал	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,555,500.00	3,060,000.00
210604	Урсгал засвар	7,555,500.00	3,060,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,871,000.00	1,884,000.00
210702	Дотоод албан томилолт	2,871,000.00	1,884,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,343,677.00	2,560,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,537,107.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	172,000.00	172,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	183,570.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,100,000.00
210807	Газрын төлбөр	42,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,336,079.00	155,002,799.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	143,136,079.00	154,052,799.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	950,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	256,740.00	35,198,796.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	19,896,570.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	19,396,570.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	256,740.00	11,729,726.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	256,740.00	11,729,726.52
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,572,500.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,572,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	10,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	10,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	10,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	10,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	10,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(10,000,000.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	444,485,100.00	421,142,843.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	444,485,100.00	421,142,843.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	406,154,600.00	401,246,273.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,511,400.00	237,429,999.77
210101	Үндсэн цалин	169,872,700.00	163,431,009.77
210102	Нэмэгдэл	58,530,200.00	60,460,659.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,108,500.00	13,538,331.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,009,000.00	31,068,880.71
210201	Тэтгэврийн даатгал	23,228,600.00	21,770,666.86

210202	Тэтгэмжийн даатгал	2,445,100.00	2,418,333.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,956,100.00	1,934,789.59
210204	Ажилгүйдлийн даатгал	489,000.00	456,158.97
210205	Эрүүл мэндийн даатгал	4,890,200.00	4,488,931.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,437,600.00	40,687,541.00
210301	Гэрэл, цахилгаан	3,960,000.00	4,210,000.00
210302	Түлш, халаалт	36,477,600.00	36,477,541.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,327,900.00	20,164,991.00
210401	Бичиг хэрэг	2,171,000.00	2,640,920.00
210402	Тээвэр, шатахуун	9,298,900.00	12,298,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,858,000.00	2,300,920.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	924,251.00
2105	Нормативт зардал	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,060,000.00	13,060,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00
210602	Тавилга	25,000,000.00	-
210604	Урсгал засвар	3,060,000.00	3,060,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,882,700.00	1,884,000.00
210702	Дотоод албан томилолт	4,882,700.00	1,884,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,926,000.00	2,560,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	172,000.00	172,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	2,100,000.00
210807	Газрын төлбөр	42,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,400,000.00	53,790,861.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,750,000.00	53,140,861.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	650,000.00	650,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,330,500.00	19,896,570.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,330,500.00	19,896,570.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,330,500.00	19,396,570.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	432,872,570.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	421,268,370.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	421,268,370.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	11,604,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	11,604,200.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	126,751,636.00	101,211,938.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	126,751,636.00	101,211,938.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	126,751,636.00	101,211,938.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,949,500.00	-
210604	Урсгал засвар	1,949,500.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,543,807.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,543,807.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,258,329.00	101,211,938.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	120,258,329.00	100,911,938.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	300,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,572,500.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,572,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	126,751,636.00	104,784,438.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	126,751,636.00	104,784,438.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	120,258,329.00	77,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,543,807.00	26,215,938.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,949,500.00	1,068,500.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Агт сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Агт сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03/19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баян-Агт сумын ЗДТГ нь сумын эдийн засгийн давуу талыг ашиглан эрчимжсэн МАА-г эрхлэх, аялал жуулчлал, дэд бүтцийг хөгжүүлэх, төсвийн орлогыг бүрдүүлэх, амьжиргааны чадавхийг нэмэгдүүлэх гол эх үүсвэр болсон жижиг дунд, хоршоо, нөхөрлөл, малчны бүл байгуулах хөдөлгөөн өрнүүлэх, идэвхий санаачлагыг бүхийл бололцоогоор дэмжих, нийгэм соёлын болон ахуйн үйлчилгээний үйлчилгээг иргэдэд ойртуулах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, төр засгийн бодлого шийдвэр, төрийн үйлчилгээг иргэдэд нээлттэй ил тодоор хүргэхгэж зорилтоо тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль -Хүчингүй болж, шинэчлэн найруулагдсан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журмын дагуу Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Агт сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардал 662,950.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,944.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 7,458.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Агт сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,217.7 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	4,613.00	11,051.90	6,438.90
Урьдчилгаа			0.00
Бараа материал	145,136.70	138,924.70	-6,212.00
Үндсэн хөрөнгө	1,405,445.10	1,303,907.60	-101,537.50
Нийт хөрөнгө	1,558,808.30	1,456,926.60	-101,881.70
Өр төлбөр	0.8	0	-0.80
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,558,807.50	1,456,926.60	-101,880.90
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,558,808.30	1,456,926.60	-101,881.70

Авлага дансны үлдэгдэл 11,051.9 мянган төгрөг болж 6,438.9 мянган төгрөгөөр өссөн нь иргэдээс авах өвс тэжээлийн авлага, дутагдуулсан хөрөнгийн барагдуулж дуусаагүй өр авлага, нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн авлага, НДШ, ХАОАТ-ыг илүү тооцон шилжүүлсэн зэргээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн 4,400.0 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна. Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 138,924.5 мянган төгрөг болж 6,212.0 мянган төгрөгөөр буурсан нь мал амьтад данснаас мал дутагдуулсан, өвс тэжээл зээлээр иргэдэд өгсөн зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь 101,537.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардал нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,456,926.9 мянган төгрөг болж 101,880.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 36,993.4 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 14,738.5 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар өссөн байна. 2021 онд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн элэгдэл, урсгал шилжүүлгийн зэрэг зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 477,638.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 33,153.7 мянган төгрөгөөр бууруулан 444,485.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 459,445.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 408,542.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 12,600.0 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 2,900.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 408,542.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 11,604.2 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 12,600.0 мянган төгрөг нийт 432,747.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 421,142.8 мянган төгрөгийг зарцуулж 11,604.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн

тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 59,799.9 мян/төг, стастиктикийн хэлтсээс 859.9, авто замын сангаас 26,700.0 төг, Булган Мээж ХХК-иас усны санхүүжилт 16,356.0, иргэдээс авах өвс тэжээлийн авлагаас 1,068.5 нийт 104,784.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 62,149.4 мянган төгрөгийг зардалд зарцуулж 6,777.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

3.8 Аудитын гол асуудал

Баян-Агт сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш 31 удаагийн 479,784.1 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 3 удаагийн худалдан авалтын 38,617.5 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- Шилэн дансанд таван сая төгрөгөөс дээш 31 удаагийн 479,784.1 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 3 удаагийн худалдан авалтын 38,617.5 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй нь шилэн дансны тухай хуулийн 6.4.4, 6.4.5 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Тэмцээн уралдаан тэмцээний зардалд 11,993.3 мянган төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.6 дахь заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам"-тай нийцээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан бөгөөд акт, албан шаардлага, зөвлөмж хүргэгдээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татхуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 479,156.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8,738.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,942.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 459,878.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 8,597.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Нэмэлт санхүүжилтээс шатахууны зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн нь Сангийн сайдын 388 дугаар тушаалын холбогдох заалт, санхүүгийн тайланийн аудитын толилуулга батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

4.2 Төлбөрийн акт

Туслах үйл ажиллагааны малчны цалингийн зардалд 1542.3 төгрөгийг зарцуулсан, туслах аж ахуйн ашиг, алдагдалын тооцоог хийгээгүй, ногоон тэжээл тарих шатахууны зардалд 400.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан нь төсвийн тухай хуулийн 44.3 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд нийт 1942.3 мянган төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

- Таван сая төгрөгөөс дээш 31 удаагийн 479,784.1 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 3 удаагийн худалдан авалтын 38,617.5 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.4, 6.4.5 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Тэмцээн уралдаан тэмцээний зардалд 11,993.3 мянган төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.6 дахь заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа хангаагүй байгаа зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Засаг даргын нөөц хөрөнгөөс байгууллагын урсгал үйл ажиллагааны зардалд 6,107.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Сангийн

сайдын 2021 оны 04-р сарын 20-ны өдрийн 61-р тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалатын нийтлэг журам"-ын 1.1, 3.1.2, Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал

1.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдлийг бүрдүүлж хавсаргаагүй, төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдэл бүрэлдэхүүн хэсгийн дагуу тайлангаа ирүүлээгүй.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

2. Цалингийн зардалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бүтэц орон тоонд батлагдаагүй E-mongolia операторын ажилтад хавсарсан ажилсны нэмэгдэл цалинд 234.2 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" тухай заалт, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

3. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Харилцагч байгууллага 1,711.7 мянган төгрөгийн Е баримтыг илүү шивсэн, тооцоо нийлж үлэгдлийг баталгаажуулахдаа тооцооны үлдэгдлийн баталгааг дутуу хийсэн нь ННБ-ийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

ННБ-ийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

4. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант онд шинээр байгууллага, хувь хүнтэй шинээр 6,651.9 төгрөгийн авлага үүсгэж Төсвийн тухай хуулин 6.4.8 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулин 6.4.8 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баян-Агт сумын ЗДТГ	9	479,156.5	1	8,738.1	1	1,942.3	3	459,878.3	4	8,597.8